

# Гэртээ ирлээ

**Буцаж ирэх үеийн Өдөр тутмын тусгал**

*Хилийн чанадад сурч амьдарч байсан хүмүүст зориулав*

Лиза Еспинелл Чинн

2011 InterVarsity Christian Fellowship/ USA

АНУ дахь InterVarsity-н Гадаад Оюутнуудын Үйлчлэлийн Багийн бичгээр баталгаажуулсан зөвшөөрөлгүйгээр энэхүү номыг дахин хэвлэхийг хориглоно.

6400 Schrodoeder Road Madison,  
Wisconsin 53711

[www.intervarsity.org/ism](http://www.intervarsity.org/ism)

Судрын ишлэлүүдийг “THE MESSAGE”-ээс авав. “NavPress” Хэвлэх группийн зөвшөөрлөөр Хэвлэн нийтлэх эрхийг Eugene H. Peterson-д 1993, 1994, 1995, 1996, 2000, 2001, 2002 онуудад олгов.

Contemporary English Version Библээс авсан ишлэлүүдийн ард (CEV) гэж тэмдэглэсэн. Хэвлэн нийтлэх эрхийг 1991, 1992, 1995 онуудад Америкийн Библийн Нийгэмлэгээс авав.

ISBN # 978-0-9835848-1-0

## Өмнөх үг

Дараахь хүмүүст гүн талархал илэрхийлье: Энэхүү хэвлэлийн анхны гар бичмэлд санал зөвлөлгөө өгсөн Доктор Боб Осберн, Жулий Стайлэс, Лооран Марлов болон Леа Чинн; нутаг буцсан түүхээ надтай хуваалцсан гадаадын олон оюутнуудад, энэ номын нүүрийг зурж бэлтгэсэн Жанет Аткинс болон график дизайныг гаргаж өгсөн Лоора Ли, Мөн Махало (Хавайн), мөн ядрахыг үл мэдэн хамтран зүтгэж дэмжсэн миний хань Лейтон Е. Чинн.

## Танилцуулга

“Би таньтай ярилцмаар байна. Таньд зав байна уу?” гэж нэг охин надаас асуулаа. Байлгүй яахав, гэж би хариулав. Дараа нь тэр охин нутаг буцсаныхаа дараа бэрхшээлтэй учирсан өөр нэг найзад нь тусламж хэрэгтэй байгааг хэлсэн юм. “Бид таньтай интернетээр уулзаж болох уу?” гэж тэр асуув. Бид интернетээр уулзаж ярилцсаны дараа тэр хоёр: “Бидэнд тохиолдож байгаа зүйлс нь хэвийн зүйлс гэдгийг мэдэхэд сайхан байлаа” гэж хэлсэн юм.

Заримдаа жирийн нэг харилцан яриа болон тулгарч байгаа зүйлдээ нэр өгөх нь гэртээ буцаж очсон шилжилтийн үед маш чухал өөрчлөлтийг авчирна. Харин та хэн нэгэн хүн рүү утасдах боломжгүй бол яах вэ? Дэргэд тань таныг ойлгох хэн нэгэн байхгүй юм уу, яахаа мэдэхгүй будилсан үедээ та яах вэ?

Энэхүү өдөр тутмын уншлагыг эх орондоо буцаж очсон эхний сард таныг чиглүүлэн туслах зорилгоор бичлээ. Библийн үгс болон товчхон бодролоор бичигдсэн энэ товхимол нь таньд буцан ирэх процессыг ойлгох, зүрх сэтгэл, оюун бодлоо Бурхан руу хандуулахад тань туслах болно.

Буцаж ирэх үед тохиолдож болох янз бүрийн үе шатуудыг энд сэдэвчлэн бичив. Таны шилжилтийн үе энд бичигдсэн сэдвүүдийн дэс дараалалтай яв цав таарахгүй, өвөрмөц байж болно. Тиймээс энэ зааварчилгааг өөрийн болгон ашиглаж, өөрийнхөө буцаж ирэх үеийн зургийг гаргаарай.

Энэ товхимолыг өөрийн найз нөхөр, хамтрагч мэт үзэж уншаарай. Бурхан таны өдөр тутмын уншлагаар дамжуулан таныг дэлхийг өөрчлөгч, дэлхийн хэмжээнд сэтгэдэг бурханлаг иргэн болгон өсгөх болтугай.

Лиза Еспанелл Чинн

Олон Улсын Оюутнуудын Үйлчлэлийн Захирал

АНУ дахь InterVarsity Христийн Нөхөрлөл

2011оны 4-р сар

## Агуулга

Эхний өдөр: **Хөгжилтэй үе шат:** Гэртээ ирэхэд сайхан.

2-р өдөр: Гэртээ тавтай морилно уу

3-р өдөр: Үндэслэгдэх ба шилжүүлэн суулгагдах нь

4-р өдөр: Шинэ ирээдүй

5-р өдөр: Өдрийн шинэ дэглэм

6-р өдөр: Өөрчлөлт

7-р өдөр: Гэр минь?

8-р өдөр: Дууриах--- Дасан зохицох #1

9-р өдөр: **Буцаад нисмээр үе шат:** Энд баймааргүй байна.

10-р өдөр: Нутгийн соёлд цочрох нь

11-р өдөр: Шинэ би

12-р өдөр: Дахин найзуудтай болох нь

13-р өдөр: Дурсамжууд

14-р өдөр: Итгэлтэй байдал

15-р өдөр: Намайг сонсох хүн байна уу?

16-р өдөр: Тусгаарлах---Дасан зохицох # 2

17-р өдөр: Найдлага

18-р өдөр: Ганцаардал

19-р өдөр: Өөрчлөлт

20-р өдөр: **Тэмцлийн үе шат:** Энд байхаас дургүй минь хүрч байна!

21-р өдөр: Гуниглал

22-р өдөр: Сэтгэлийн шаналал

23-р өдөр: Алдаа гаргах нь

24-р өдөр: Шүүмжлэмтгий авир

25-р өдөр: Шийдвэрүүд гаргах нь

26-р өдөр: **Дасах үе шат:** Энэ бол миний гэр орон

27-р өдөр: Нэгтгэх--- Дасан зохицох # 3

28-р өдөр: Итгэлээ сэргээх нь

29-р өдөр: Өөр хэн нэгнийг явуулаач

30-р өдөр: Энэ цагийн төлөө ч юм бил үү

Төгсгөлийн үг/ Хавсралт

## **Эхний өдөр: Хөгжилтэй үе шат: Гэртээ ирэхэд сайхан.**

*Энэ өдөр та нарын хувьд дурсгал болж, та нар үүнийг Эзэний баяр болгон үе уламжлан үүнийг зарлиг болгон тэмдэглэ.*

*(Гэтлэл 12:14, Ариун Библи 2013)*

“Энд ёстой гоё юмаа” гэж Америк дахь оюутны хотхондоо шинээр ирсэн гадаад оюутан сэтгэл хөдлөн хэлж билээ. Тэр шинэ хүмүүстэй уулзаж, орчин тойронтойгоо танилцаж, их баяр хөөртэй байгааг бид харж байлаа. Тэр гарцаагүй шилжилтийн үеийнхээ хөгжилтэй шатанд байсан юм.

Та ч мөн яг л ийм байгаа бизээ.

Буцаж ирэх үед, энэхүү Хөгжилтэй үе шат нь дахин давтагддаг. Энэ шатанд гэрийн үнэр, дуу чимээ, алсын бараа гээд бүх зүйлс үнэхээр сайхан. Таньд одоо яг л ийм байгаа. Та цагийн зөрүүндөө дасч, сайхан унтаж амарна. Нүүр хуудсан дээр ирсэн зургаа тавина. Та санаж үгүйлж байсан гэр бүл найз нөхдөөрөө хүрээлүүлэн сууна. Та авчирсан бэлгээ тэдэндээ тарааж, үгүйлж байсан амьдралын хэмнэлдээ орж, удаан хүлээж байсан гэрийнхээ хоолыг иднэ.

Амьдрал сайхан байна.

Гэтлэл номын түүхийг та санаж байна уу? Бурхан Израйлчуудыг Египитээс гаргасан тэр өдрийг тэд түүхэндээ тэмдэглэн үлдээсэн юм. Тэд хойч үеийнхэндээ сануулахын тулд Дээгүүр өнгөрөх баярыг жил бүр тэмдэглэдэг. Та эргэн ирсэн энэ үеээ сайхан өнгөрүүлээрэй. Зарим дурсамжуудаа мартаггүйн тулд тэмдэглэл хийгээрэй.

## **Тунгаан бодох нь:**

Гэтлэл 12-ийг унших.

Мөн та гэртээ ирсний баяраа тэмдэглээрэй.

\*Шилжилтийн үе дөрвөн үе шаттай. (Хавсралтыг харна уу)

## **2-р өдөр: Гэртээ тавтай морилно уу.**

*Аяа, Эзэн, Та намайг судлан намайг мэдлээ. Миний сууж, босохыг Та мэддэг бөгөөд хаа холоос санаа бодлуудыг минь ойлгодог. Та миний зам мөр хийгээд хэвтэхийг минь ч нарийвчлан үзэж, замнал бүрийг минь ч нарийвчлан мэддэг. Хэлэн дээр минь ганц үг ч байхаас өмнө, Харагтүн, Эзэн Та бүгдийг мэддэг. Та хойноос ба урдаас минь нөмөрлөж, миний дээр мутраа тавьсан. Мэдлэг нь надад дэндүү гайхамшигтай өндөр бөгөөд би түүнд хүршгүй билээ. (Дуулал 139:1-6, Ариун Библи 2013)*

“Гэртээ тавтай морилно уу” Гэвч энэ үнэхээр таны гэр мөн үү? Магадгүй “Буцаж тавтай морил” гэж мэндлэх нь илүү оновчтой байж болох юм. Гэртээ буцан ирэх нь яг л хоёр өөр ертөнцөд байгаа мэт. Хүн судлаач, Христитгэгч Доктор Мириам Адени гадаадад амьдарч байгаа оюутнууддаа хэлэхдээ: “Тэд хэзээ ч бүрмөсөн гэртээ ирэх боломжгүй, тэдний сэтгэлийн нэг хэсэг нь үргэлж тэндээ үлдэж, хуваагддаг” гэжээ. Тэгэхээр гэр бол нэгээс илүү газар байж болох нь. Гэвч энэ бол нэгээс илүү орны амьдралын баялаг туршлагынхаа төлөө тэдний төлөх төлөөс юм.”

Бурхан таныг мэднэ, соёлын өөр орчинд ирсэнийг тань ч бас мэдэж байгаа. Тэр таны хэзээ явсныг ч, хэзээ эргэн ирснийг ч бас мэднэ. Тэр таны гэртээ ирсний баяр хөөр болон уйтгар гуньгийг ойлгодог. Бурхан таныг маш сайн мэддэг гэдгийг санаарай. Тэрээр таныг хэзээ ч орхихгүй, танд хамгийн ойрхон байна. *“Бурхан бол бидний хүчит цайз ба зовлон шаналал дунд үнэхээр олддог тусламж юм.”*

(Дуулал 46:1, Ариун Библи 2013)

## **Тунгаан бодох нь:**

Гадаадад сурч эсвэл амьдарч байсан хэн нэгнийг олж уулзаад сэтгэл санаагаа хуваалцаараарай.

Дуулал 139:1-6-г цээжлэх.

### **3-р өдөр: Үндэслэгдэх ба шилжүүлэн суулгагдах нь**

*“Итгэлээр Абрахам, өв болгон авах гэж байсан нутаг руу явахаар дуудагдахдаа дуулгавартай байв. Тэр хаашаа явж байгаагаа ч мэдэлгүй гарч явав. Итгэлээр тэр, адилхан амлалтыг хамтран өвлөгчид болох Исаак, Иаков нартай майханд амьдарч, амлалтын газарт харийн нутагт буй мэт суусан. Учир нь Абрахам суурь бүхий хотыг хүлээж байсан юм.” (Еврей 11:8-10, Ариун Библи 2013)*

Олон сая гадаад оюутнууд, цагаачид, дүрвэгчид болон бусад түр оршин суугчид дэлхий даяар үндэслэгдэж, шилжүүлэн суулгагдаж байдаг.

Та харийн нутагт амь зууж, магадгүй хөгжин дэвжсэн байх. Харин одоо та өөрийн эх орны хөрсөнд дахин суулгагджээ.

Та шилжилтийн үеийг амсаж буй цорын ганц хүн биш шүү. Бурханы ажил нь нүүдэлчин хүмүүсийн эргэн тойронд хийгдэж байдаг. Тэрээр тэдгээр хүмүүсийг сонгож, байх ёстой газар руу нь дууддаг. Тэд Түүнийг сонсоод ирээдүйд юу угтаж байгааг мэдэхгүй ч шилжин нүүж байдаг.

Еврей 11-д Абрахамын аян нь итгэлийн үйл байсныг өгүүлдэг. Бурханд итгэх түүний итгэл нь түүний амьдралыг тодорхойлж, түүнийг ирээдүй рүү нь чиглүүлсэн юм. Таны өөр соёл иргэншил рүү аяалсан аялал нь таны итгэлд хэр зэрэг шалгуур болж байна вэ? Ирээдүйгээ та хэрхэн төсөөлж байна вэ? Та үнэхээр хаашаа явж байна вэ?

### **Тунгаан бодох нь:**

Еврей 11:8-10-ийг уншиж тунгаан бодох.

Тарих ургамал сонгон аваад шинэ саванд юмуу эсвэл өөр газарт шилжүүлэн суулгаарай.

Үүнийгээ та өөрийнхөө итгэлийн аяны замд нүдэнд харагдах санамж болгож ашиглах юмуу, эсвэл үндэслэгдээд шилжүүлэн суулгагдсан өөрийн туршлагаа зурж болно.



#### **4-р өдөр. Хэтийн шинэ төлөв**

*Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд Тэр нь одоо соёолж гарна. Та нар үүнийг мэдэхгүй гэж үү? Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана. (Исаиа 43:19, Ариун Библи 2013)*

Хил давсаны дараа хэтийн төлөв өөрчлөгдөх нь хэвийн үзэгдэл билээ. Та одоо буцаж ирээд таны ертөнцийг үзэх хүрээ тэлж, шинэ амт, шинэ мэдрэмж (хүсэл эрмэлзлэл) болон эн тэргүүнд тавих зүйлс тань өөр болсоныг та анзаарна.

Таны дэлхий нийтийн талаархи мэдлэг нэмэгдэж, шинэ үйл ажиллагаа, шинэ хэрэгцээ, эсвэл шинэ бүлгийн хүмүүсийг дэмжин сурталчилна. Таны хүсэл эрмэлзлэлийг хуваалцах өөр хэн байна вэ?

Та шинэ төрлийн хоол идэж, хоол хийх шинэ аргуудтай танилцана. Харин та тэдгээр шинэ хоолыг хийж чадах болов уу? Эсвэл та ойролцоох ресторанд очиж тэр хоолыг амталж үзэх үү?

Таны хөгжмийн сонирхол тэлж, өөр орнуудын дуу хөгжимд дуртай болсон байгаа. Тэр дуунуудаасаа татаж авах боломж таньд байна уу?

Магадгүй та шинэ авъяас чадварыг эзэмшсэн бол түүнийгээ хаана хэрхэн ашиглаж болох вэ?

Мөн та амралт чөлөөт цагтаа зориулан спортын шинэ төрөл, тоглоомууд сурсан бол тэднийгээ энд хийх боломжтой юу? Бас хэнтэй хамт тоглож болох вэ? Та Бурханы Үг рүү хүсэн тэмүүлдэг болж залбирал дээрээ өссөн байж болох. Та ойлгож авсан зүйлээ хэрхэн тэмдэглэж авч байна вэ?

Таньд юу юу хэрэгтэй байна вэ? Та улс төр, өнөөгийн байдлын талаархи уулзалт ярианд дуртай бол таньтай адил сонирхолтой хэн байна вэ?

Бурхан таны дотор шинэ зүйлийг хийх гэж байна. Өөр соёлын сайн сайхан зүйлсэд баярладаг олон улсын иргэн болгон таныг төлөвшүүлэн өөрчлөх боломжийг Бурханд олгоорой.

#### **Тунгаан бодох нь:**

Та өөрийнхөө тухай “өмнөх ба дараахь” тодорхойлолтыг бичнэ үү?

Гадаадад байхдаа та ямар хүн байсан бэ? Харин одоо та хэн бэ?

## **5-р өдөр: Өдрийн шинэ дэглэм**

*Аяа, Хамгийн Дээд Нэгэн, ЭЗЭНд талархлыг өргөн, Таны нэрд магтан дуулах нь сайн. Өглөө Таны хайр энэрлийг, шөнөөр Таны үнэнийг арван утаст ятгаа болон босоо ятгаар, ятгын ая дуугаар тунхаглах нь сайн. (Дуулал 92:1-2. Ариун Библи 2013)*

Та гэртээ ирснээс хойш нэг л эвээ олохгүй, будилж байж магад. Таны урьдын тогтсон өдрийн дэглэм өөрчлөгдөж, та одоо өөрийнхөө амьдралд хэвийн байдал тогтоохыг хичээж байгаа бизээ.

Өдрийн дэглэм нь таны тав тухтай байхад хэрэгтэй. Энэ нь таныг хүнийрхүү байдлаас гаргана. Цагийн хуваарь нь өдөр тутмын хэмнэлээ олоход таньд тусална.

Дуулал номыг бичигч нь 92-р бүлэгтээ өөрийнхөө өдрийн дэглэмийн тухай дурджээ. Тэр юу сайн болохыг өгүүлсэн: Түүний хувьд Бурханыг магтаж, хөгжим дуу зохиох нь сайхан байсан. Түүний өглөөний зан үйл нь Бурханы хайрыг магтаж, оройд Бурханы итгэмжит байдлыг тунхагладаг байсан. Ингэж тэр тухайн өдрөө Бурхантай эхэлж, Бурхантай дуусгадаг байжээ.

Та нутагтаа буцаж ирснээс хойш, хэт завгүй амьдрал руу орсон байж магадгүй. Та хүмүүстэй уулзаж, ярьж хөөрөх хэрэгцээ шаардлагатай тулгарч тал бүр тийшээ харайсаар өдрийн дэглэм тогтоох сөгөөгүй, зогсох завдалгүй байгаа бизээ. Эсвэл үүний эсрэгээр ч байж магад. Ямартаа ч таны цаг таны л гарт байгаа. Хэдийгээр цаашид та юу болохыг тааж мэдэхгүй ч, өөрийнхөө амьдралд зарим нэг хэв журмыг тогтоохыг хичээгээрэй. Өглөөгүүр аяга цай юмуу кофе уух, ойр зуур алхах, өдөр тутмын чимээгүй цаг гаргах гэм мэт энгийн зүйлсээс эхэлж болно.

Өөрийнхөө өдрүүдэд зарим нэг дэг журмаар “зангуу” тавь. Та цагийн хуваарьтаа хэзээ зогсож, Бурхантай холбогдон, Түүний Үгээр амьсгалах цагаа товлон тэмдэглээрэй. Энэ үнэт цагаа хамгаал. Учир нь энэ цаг мөчүүд бол таны амьдралын гол шугам ба аврах татлага мөн билээ.

### **Тунгаан бодох нь:**

Энгийн хуваарь гаргаад, үүнийгээ хариуцлагатай мөрдөхийн тулд найзтайгаа хуваалцаарай.

## **6-р өдөр: Шилжилт**

*Тэгээд Мосе ба Израилийн хөвгүүд ЭЗЭНд энэ дууг дуулжээ: ЭЗЭНдээ дуулнам би. Хүлэг морийг унаачтай нь далайд Тэр хаяж, Үлэмж өргөмжлөлийг Өөртөө Тэр авчээ. (Гэтэлгээ 15:1, Ариун Библи 2013)*

*Ард түмэн Мосед гонгинолдон: “Бид юу уух вэ?” гэцгээв. (Гэтэлгээ 15:24, Ариун Библи 2013)*

Уулс, хөндийнүүд нь хэвийн шилжилтийн дүр төрхийг харуулдаг. Сэтгэл санаа нэг өдөр өндөр байхад, нөгөө өдөр нь гунигтай, яах учраа мэдэхээ больдог.

Египетээс амлагдсан нутаг руу гарсан их нүүдэл бол үнэхээр гайхалтай түүх юм. Бурхан удаа дараагийн гайхамшигуудыг үйлдэж, тэдний амьдралд оролцсоор байсан. Бид энэ түүхийг уншиж байхдаа, Фараон Бурханы хүмүүсийг суллах болов уу? гэж түгшин хүлээдэг. Тэднийг дээгүүр өнгөрөх баярын зоог бэлтгэж байгаа хэсэгт бараг л түргэлээчээ гэж хэлмээр сэтгэл яардаг. Энэ агуу шилжилтийн үед Израйлчуудын сэтгэлийн хөдөлгөөнийг ажиглавал, ямар их дээш, доош хэлбэлзэж байсныг та харах болно.

Улаан тэнгисийг гаталсаныхаа дараа Мосе болон Израйлчууд Эзэнд хандан магтан дуулсан. Тэд юу болсныг өөрсдийн нүдээр харж асар ихээр хөөрөн баярласан. Гэвч тэдний энэ их баяр хөөр нь удаан үргэлжилсэнгүй. Цөлд хэд хоносны дараа Израйлчууд “Бид юу уух юм бэ? гэж гонгинолдож эхэлсэн. (Гэтэлгээ 15:1) Бурхан тэднийг усаар хангаж, 12 булаг шанд, 70 далд мод руу хөтлөн аваачсан юм.

Египетээс гарснаас хойш 2 сарын дараа тэд дахин гомдоллож: “Бид Египетийн нутагт махтай тогооны хажууд сууж, цадталаа талх иддэг байхдаа ЭЗЭНий мутарт алагдсан бол дээр байж. Та нар чуулганыг бүхэлд нь өлсгөлөнгөөр алах гэж биднийг энэ цөлд авчирлаа” гэцгээсэн. (Гэтэлгээ 16:3, Ариун Библи 2013)

### **Тунгаан бодох нь:**

Та шилжилтийн аль үедээ байна вэ? Дээшээ юү? Доошоо юү?

Та юунд баярлаж, юунд гомдоллож байна вэ?

## 7-р өдөр: Гэр?

*ЭЗЭН ингэж айлдаж байна: «Вавилоны төлөө далан жил дуусахад та нарыг энэ газарт буцааж авчрахын тулд Би та нар дээр ирж, сайн үгээ та нарт биелүүлнэ. Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм» гэж ЭЗЭН тунхаглаж байна. «Та нар Намайг дуудаж, ирж, Над уруу залбирахад Би та нарыг сонсоно. (Иеремиа 29:10-12, Ариун Библи 2013)*

Та гадаадад байхдаа гэр орныхоо олон зүйлийг үгүйлэн санасан нь мэдээж. Харин одоо та гэртээ ирж тэдгээр зүйлстэйгээ хамт сэтгэл хангалуун байгаа бизээ. Чухам юу таньд сайхан байна вэ? Танай соёл уламжлал уу? Ээжийн хийсэн хоол уу? Ганцаараа байгаа нь уу? Гэр орны эдгээр зүйлс нь таньд сайхан байгаа хэдий ч амьдралынхаа бүхий л хэв маягт нэг л дасахгүй байгаа. Таньд яг л замын урсгал сөрөөд бартаатай замаар алхаж байгаа юм шиг сэтгэгдэл төрж магад.

Тэгэхээр та одоо яах вэ?

Энэ бүх шилжилт хөдөлгөөний дотор Бурханы төлөвлөгөө байгаа. Иеремиа Вавилонд буй цөлөгсдөд шинэ нутаг орондоо дасаж, амьдрал руу нь орж, сайн сайхан зүйлсийг нь олж харахыг сануулдаг. Энэ их өөрчлөлтийн дунд Бурхан тэдэнд санаа тавьж байсан бөгөөд Тэрээр юу хийж буйгаа сайн мэдэж байсан юм. Харин цөлөгсөдийн хувьд Бурханд тэдний төлөвлөгөө үнэхээр байгаа шүү гэдэгт итгэх хэрэгтэй байлаа. Тэд харь нутагт оршин сууж байх үедээ Бурханыг дуудаж байсан ба энэ нь тэднийг Бурхан руу улам ойртуулахын тулд байсан юм. Шилжилтийн үед байх нь Бурханд итгэлээ өгөх онцгой боломж юм шүү.

## Тунгаан бодох нь:

Энэхүү тохируулгын үе шатанд Бурхан таныг Өөр рүүгээ улам ойртуулж байна. Та Түүний талаар болон өөрийнхөө талаар юуг олж мэдсэн бэ? Хариултаа бичиж тэмдэглэх юмуу, эсвэл найзтайгаа хуваалцаарай.

## **8-р өдөр: Дууриах--- Дасан Зохицох #1**

*Учир нь би бүгдээс чөлөөтэй атлаа илүү олныг олж авахын тулд өөрийгөө бүгдэд боол болгосон...*

*Сул доройчуудыг олж авахын тулд би сул доройчуудад сул дорой нэгэн адил болсон юм. Бүхий л аргаар заримыг нь аврахын тулд би бүгдэд бүх юм болж байлаа. Би сайн мэдээний ерөөл хуваалцагч байхын тулд үүний төлөө бүхнийг хийдэг. (1 Коринт 9:19, 22-23; Ариун Библи 2013)*

Шинэ соёлыг сурч, зарим зүйлийг дууриах нь чухал. Хүн судлаачид үүнийг “нутгийн хүн болох” гэж нэрлэдэг. Үүнтэй адил, та ч мөн эх орондоо дасан зохицохын тулд хэв маяг, хэм хэмжээг нь дагах хэрэгтэй. Та шинээр ирсэн хүний хувьд ажигла. Үзэж харж байгаа зүйлсээ баримжаалан тайлж ойлгож ав. Дараа нь та шинээр мэдэж авсан зүйлээ туршаад үзээрэй. Хүмүүс таньд (үгээр ба үггүйгээр) хариу үйлдэл үзүүлж, зарим үед та засаж залруулах шаардлага гарна.

Гэхдээ, та өөрийн соёлоос тэс өөр хүн бишээ. Магадгүй та Монголоо алдаагүй, монголжуу байдлаараа байж болно. Элч Паул, өөр улс орны соёлд амьдрах маш сайн зарчмыг бидэнд зааж өгсөн юм. Тэр хэнтэй харьцахаа сонгох эрхтэй эрх чөлөөт хүн байсан хэдий ч өөрөөсөө тэс өөр хүмүүсийн ертөнцөд өөрийгөө зориуд оруулж чадсан. Түүний зорилго нь сайн мэдээний төлөө гүүр тавих явдал байлаа.

Өөр соёл, ёс заншлыг дууриахдаа заавал бүгдийг нь юмуу эсвэл хамаа намаагүй даган дуурайж уусна гэсэн үг биш юм. Та юуг дууриах, юуг дуурайхгүйгээ сонгоорой. Эх орондоо эргээд дасан зохицохын тулд зарим зүйлийг дууриах шаардлагатай ч өөрийн итгэл бишрэл болон хувь хүнийхээ эрхэмлэх чанараа алдахгүй байх нь зүйтэй.

### **Тунгаан бодох нь:**

Таны ертөнцийг үзэх үзлээс огт өөр үзэлтэй ямар хүмүүс таны эргэн тойронд байна вэ?

Тэдний ертөнцөд та хэрхэн орох вэ?

## **9-р өдөр: Нислэгийн шат: Би энд баймааргүй байна.**

*ЭЗЭН бүх замдаа зөвт бөгөөд Өөрийн бүх үйлсэд энэрэнгүй. Эзэн Өөрийг нь үнэнээр дуудагч бүхэнд ойр билээ. (Дуулал 145:17-18, Ариун Библи 2013)*

Эдгээр үе шатуудыг унших явцдаа, таньд энэ бүхэн зайлшгүй тохойлдоно гэсэн үг биш гэдгийг санаарай. Эдгээр нь амьдралд тохиолдож болох зүйлийн дүрслэл юм.

Таны Хөгжилтэй шат ирсэн шигээ хурдан өнгөрч, харин яг одоо та сэтгэлийн элдэв хөдөлгөөнд автаж байж болох. Жишээ нь: Хэт яриасаг, эсвэл эрх чөлөө нь хэтэрчихсэн хүмүүсийг тэвчих таны тэвчээр алдарна. Таны найзууд таны гадаад дахь амьдралын тухай нэг их сонирхож асуухгүй байгаад сэтгэл гонсойно. Магадгүй та гадаадад байх үеийн чөлөөт байдал, сүнслэг гал цогтой орчноо хүсэмжилж, гэр орон тань уйтгартай санагдаж болох юм.

Хэрэв та ийм байгаа бол Нислэгийн шатандаа байна гэсэн үг. Энэ шатанд амьдрал таны төсөөлж байснаас өөр байдаг. Та ирсэн газар руугаа буцаад нисмээр, эсвэл та ганцаараа баймаар санагдаж болзошгүй.

Өөрийн сэтгэл санаа ямар байгаагаа өөрөөсөө нуух гэсний хэрэггүй, гэхдээ ямар нэгэн яаруу шийдвэр бүү гаргаарай.

Бурхан Өөрийг нь дуудагч хүн бүхэнд ямагт ойр байдгийг Дуулал номыг бичигч нь таньд сануулжээ. Тэрээр таны урам хугаралт, таны дургуйцэл болон цухалдлыг мэдэж байгаа. Бурхан таньтай ойрхон байгаа гэдгийг мэдэх нь таны шилжилтийн энэ үед бодит өөрчлөлтийг авчрах болно. Түүнийг дахин дахин дуудаж байгаарай.

### **Тунгаан бодох нь:**

Бурханд гомдлын захиа бичих. Энэ үед таны сэтгэл санаа ямар байгаагаа шударгаар нуулгүй уудлан илэрхийлээрэй.

## 10-р өдөр: Нутгийн соёлд цочрох нь.

*Хашхирахыг минь сонсооч, Бурхан. Залбиралд минь чих тавиач. Зүрхээ цөхрөн доройтоход, газар дэлхийн хязгаараас би Таныг дуудаж байна. Надаас өндөр хад уруу намайг хөтлөн гаргаач. Учир нь Та надад Хоргодох газар, дайсны урдах бат бэх цамхаг билээ. (Дуулал 61:1-3, Ариун Библи 2013)*

Америкт суралцаж төгссөнийхөө дараа би Филиппин рүү буцаж очоод үнэхээр цочирдож билээ. Жолооч нар замын шугамаасаа орж гараад л, дохиогоо орилуулаад л, бөөн хүмүүс автобусанд чихцэлдэж ороод л. Яанаа, би энд яаж амьдарнаа гэж үнэхээр айсан!

Нутгийн соёлд цочрох гэдэг нь эх орондоо ирсэн үед тохиолдох түр зуурын таагүй байдал, үл итгэл ба төөрөгдөл юм. Энэ нь юмсыг хийж байгаа хэвийн арга барил, юмуу эсвэл одоогийн шинэ бодит байдалд таны зүгээс үзүүлж буй сэтгэл хөдлөлийн хэвийн хариу үйлдэл юм.

Нутгийн соёлд цочрох нь гадны соёлд цочрохоос илүү хүнд тусдаг. Учир нь та төсөөлөөгүй зүйлдээ бэлтгэлгүй байдаг. Тиймээс та яах учраа олохгүй байх, бухимдах, уурлах, сэтгэлээр унах, ганцаардах гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнд автаж магад.

Дуулал номыг бичигч нь сэтгэлийн зовиуртай үедээ Бурхан руу хандан залбиран хашгирсан. Хэдийгээр түүний зовлон таныхаас өөр байсан ч, нэг л Бурхан сонсож, бас хариулдаг билээ.

Бурхан таны эргэн ирэх үеийн соёлын шокыг ойлгож байгаа болов уу? Мэдээж, Тэр ойлгож байгаа. Түүний тусламж мэдээллээр (Энэ бол шилжилтийн үеийн хэвийн явц бөгөөд цагийн эрхээр багасна гэсэн мэдээлэл), эсвэл өөрчлөлтөөр (таныг илүү тэвчээртэй, бага шүүмжилдэг болгох замаар таны хандлагыг өөрчилнө) дамжуулан ирнэ.

**Тунгаан бодох нь:** Таныг нутгын соёлын цочролд оруулж байгаа шалтгаануудыг бичнэ үү. Эдгээрээс таны өөрчилж чадах нь юу байна вэ? Харин таны өөрчилж чадахгүй нь юу байгааг нэрлэнэ үү?

## **11-р өдөр: Шинэ Би**

*Мосе хадам эцэг Мидианы тахилч Иетрогийнхоо хонин сүргийг хариулж байв. Тэрээр сүргийг цөлийн араар тууж, Бурханы уул Хоробт хүрчээ. ЭЗЭНий тэнгэр элч өргөст бутан дундаас галын дөлөн дунд түүнд үзэгдэв. Харагтун, бутанд гал дүрэлзэж байсан боловч бут шатахгүй байгааг Мосе харлаа. (Гэтлэл 3:1-2, Ариун Библи 2013)*

Энд байдал өөр гэдгийг та мэдэж байгаа. Шинэ хүмүүс, шинэ хэл, ертөнцийг үзэх таны шинэ үзэл гээд таны зүрх сэтгэл, оюун бодол тэлэгдсэн.

*Гэвч та ганцаардаж байгаа.*

Дээр үед хүмүүс мөн л энэ замыг туулсан. Жишээ нь Мосе олон удаагийн шилжилтийн үеийг даван туулсан юм. Тэр еврей эцэг эхээс төрж, Египетийн гүнжид өргүүлж, төрүүлсэн ээжээрээ асарч өргүүлсэн. Тэр Египетийн соёл иргэншил дотор эрх мэдэл бүхий амь амьдарч байсан юм. Гэвч тэр өөрийн гарал үүсэл болон ард түмнийхээ зовлон гачаалыг ч бас мэддэг байсан. Түүний боолчлолын эсрэг эх оронч, хүчирхийллийн үйлдэл нь Египет хүний аминд хүргэж, Мосе дайжин зугтаасан.

Тэрээр гэр орноосоо алс хол амьдарч байхдаа эхнэр авч гэрлэсэн. Гэтлэл 2:22д Мосе ууган хүүдээ Гершом (Цагаач) гэдэг нэр өгөөд харь газар цагаач болсноо хэлдэг. Тэр цөлд амьдарч байхдаа, Египэтээс зугтаан гарч байсан хүнээс тэс өөр хүн болсон гэдгээ мэдэж байсан.

Бурхан цөлд байхад нь түүнтэй ярьсан юм.

Зарим үед таньд эх орондоо байх нь цөлд байгаа мэт сэтгэгдэл төрж магад. Гэвч, Бурхан таныг мартаагүй, таны төлөөх Өөрийн төлөвлөгөөг мартаагүй.

### **Тунгаан бодох нь:**

“Цөлд” Бурхан таньд юу гэж хэлж байна вэ?

Одоо та хэн болсон бэ?

Гэр бүлийнхэн юмуу найз нөхдөөсөө таны юу өөрчлөгдсөнийг асуугаарай.



## **12-р өдөр: Дахин найз нөхөдтэй болох нь**

*Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр билээ. Тэгвэл тэдний зүтгэл сайнаар хариулагдах болно. Хэрэв тэд хамтдаа ойчих аваас нэг нь нөгөөгөө босгоно. Харин ганцаар байгч унахад түүнийг босгох хүн үгүй тул, хөөрхий. (Номлогчийн Үгс 4:10, Ариун Библи 2013)*

Та гадаадаас ирснээс хойш найз нөхдийн хүрээллээ дахиад эхнээс нь эхлэх хэрэгтэй мэт санагдаж байна уу? Ард үлдсэн таны найз нөхөд таныг одоо ямар байгааг мэдэж байгаа юу? Та найз нөхөдгүй болсон мэт санагдаж байна уу? Хэрэв тийм бол та буцаж ирснээс хойшхи нийгмийн амьдралдаа дүгнэлт хийх цаг болжээ.

Хэдийгээр таны эх оронд байгаа найз нар ямар нэг хэмжээгээр таныг ойлгох ч гадаад дахь амьдралыг тань бүрэн ойлгож, хуваалцаж чадахгүй нь үнэн юм. Та өөрчлөгдсөн байхад, тэд яг урьдынхаараа байгаа мэт таньд санагдана. Эсвэл тэдний амьдрал ч бас өөрчлөгдөж, тэдний амьдралд тохиолдсон олон үйл явдлыг та мэдэлгүй өнгөрсөн ч байж магад. Гэвч энэ нь найз нөхдөө өөрчил гэсэн үг биш шүү. Харин найз нөхдийнхөө хүрээллийг тэлээрэй гэсэн санаа юм.

Гадаадаас ирснээс хойш, та өөртэйгээ адил хүмүүстэй уулзахыг хүсч буйгаа анзаарна. Та өөрийн эрхгүй тийм хүмүүсийг хайж, группт нь нэгдэж, үйл ажиллагаануудад нь оролцож, тэдэнтэй ярьж хөөрч, туршлагаа солилцохыг хүснэ. Нүүр хуудсандаа гадаадад амьдарч байсан найзуудаа нэмнэ.

Энэ бүхэн эргэж ирсний дараахь хэвийн үзэгдэл юм.

Номлогчийн Үгс номон дахь ухаалаг үгс нь таньд ганцаараа байж болохгүй гэдгийг сануулж байна. Таньд найз нөхөд хэрэгтэй. Таны амьдралд туслах хүмүүс хэрэгтэй.

### **Тунгаан бодох нь:**

Та өөрийнхөө шинэ хүсэл сонирхлоо жагсаан бичнэ үү?

Эдгээр хүсэл сонирхлоо та хэнтэй хуваалцах вэ? Та тэдэнтэй яаж уулзах вэ?

### **13-р өдөр: Дурсамж**

*Эздийн Эзэнд талархагтун, Түүний хайр энэрэл мөнхийнх. Агуу гайхамшгуудыг ганцаар үйлдэгч Түүнд талархагтун, Түүний хайр энэрэл мөнхийнх. (Дуулал 136:3-4, Ариун Библи 2013)*

Одоо таньд нутгаасаа хол байх үеийн дурсамжууд л үлджээ. Тэдгээр дурсамжууд зүрх сэтгэлд хадгалагдаж, үе үе бодогдоно. Бурхан өөрийн хүмүүсээ эргэн дурсаж байхыг хүсдэг. Тэрээр тэднийг Өөрийн хийсэн агуу үйлсүүдийг мартаасай гэж хүсдэггүй. Бурхан түүхэн дэхь Түүний оролцоог өөрийн ард түмэнд дахин сануулж, тухайн цаг хугацаа, газруудыг тэмдэглэж авахыг тэднээс хүсдэг.

Бурханы хийсэн үйлсийг эрүүлээр нэхэн санах нь талархах сэтгэлийн үрслүүр болдог. Та оюун бодлоо таны амьдралд хийсэн Бурханы үйлсээр тэжээх тусам та талархал, итгэл ба найдвараар өндийн босдог.

Эх орондоо эргэн очих нь дурсамжийн сангаа шалгах сайхан цаг мөн. Та гэрээсээ хол амьдарч байхдаа хир зэрэг нөөц хуримтлуулсан бэ?

Сургуулиа төгсөөд Филиппин рүү буцахын өмнө миний хийсэн нэг зүйл бол Бурхан миний залбиралыг янз бүрийн замаар яаж хариулсаныг бүгдийг нь бичиж тэмдэглэсэн юм. Жишээ нь, Би Бурханаас найз гуйсан гэж бичээд Америкт танилцсан олон найз нөхдийнхөө нэрийг хуудас дүүртэл бичсэн.

Дуулал 136 бол Израйлын түүхэнд дэхь Бурханы үйлсүүдийн жагсаалт юм. Энд “Түүний хайр энэрэл мөнхийнх” гэдэг өгүүлбэрийг Бурханы хийсэн үйлс нэг бүрийн дараа оруулсан байдаг. Тэдгээр үйлсүүдийг уншихад Бурханы хайр үнэхээр мөнхийн гэдгийг бидэнд эргэн сануулдаг.

### **Тунгаан бодох нь:**

Дуулал 136-г уншаад өөрийн хувилбарыг бичнэ үү.

## **14-р өдөр: Итгэлтэй байдал**

*Эцэг нь бүхнийг мутарт нь өгснийг болон Бурханаас ирээд Бурхан өөд буцан явж байгаагаа Есүс мэдээд, зоогийн ширээнээс босож, гадуур хувцсаа тайлан, алчуур авч бүслэв. Тэгээд саванд ус хийж, шавь нарынхаа хөлийг угаагаад, бүсэлсэн алчуураараа арчиж эхлэв. (Иохан 13:3-5, Ариун Библи 2013)*

Итгэлтэй байдал гэдэг нь та хэн болохоо, хаанаас ирснээ мэдэж буйн илэрхийлэл ба оюун санааны тэнцвэр мөн. Гэсэн хэдий ч хил даван аялах, өөр оронд амьдрах үед итгэл алдрах тохиолдол байдаг. Филиппинд манай гэрт амьдарч байсан Денмарк оюутан манай орны соёлд учраа олохоо болиод: “Би уснаас гарсан загас шиг л байна” гэж хэлж билээ.

Хэдийгээр та гадаадад амьдарч байхдаа илүү итгэлтэй байсан ч эх орондоо эргэж ирээд таны өөртөө итгэх итгэл түр зуур буурч магадгүй.

Та сүнслэг тэмцэлд орж, таныг болон таны нөхцөл байдлыг өөрчилж чадах Бурханы хүчинд эргэлзэж болзошгүй. Гадаадад байх үед Бурхан таны амьдралд хэрхэн оролцож, хийж байсан Түүний үйлсүүдийг нь та санагалзаж, харин одоо Бурхан таньд санаа тавихгүй, хол байгаа мэт санагдана. Нутагтаа очсон нэгэн оюутан залуу ажилгүй олон сар болох үедээ Бурханд итгэх итгэл нь навс унасан тухайгаа ярьж билээ.

Иохан 13-р ишлэлд, Есүс дагалдагчдынхаа хөлийг угаахаас өмнө Тэрээр дөрвөн зүйлийг мэдэж байсныг өгүүлдэг. 1. Өөрийн дэлхий дээр амьдрах хугацаа дуусч буйг, 2. Өөрийн хүч чадлыг, 3. Өөрийн гарал үүслийг, 4. Өөрийн очих газрыг мэдэж байсан. Өөрийнхээ хэн гэдгийг мэдээд Есүс үйлчилсэн юм.

### **Тунгаан бодох нь:**

Бурхан болон өөрийнхөө тухай ямар үнэнийг та санах хэрэгтэй байна вэ?

Эдгээр үнэнүүд нь таныг бусдын төлөө үйлчлэхэд хэрхэн туслах вэ?

## **15-р өдөр: Хэн сонсох вэ?**

*Хэрэв би бүх өмч хөрөнгөө тараан өгч, биеэ шатаахаар тушаасан ч надад хайр үгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм. Хайр тэвчээртэй энэрэнгүй билээ. Хайр атаархдаггүй. Хайр агсганадаггүй, ихэрхдээгүй. (1Коринт 13:3-4а, Ариун Библи 2013)*

Таньд гадаадын амьдралынхаа тухай ярих зүйл их байгаа. Хүмүүс таныг сонсоосой гэж мэдээж та хүснэ. Харамсалтай нь хүмүүс өөрсдийн амьдралд автаад таныг сонсох завгүй юмуу эсвэл нэг их сонирхохгүй ч байж магад.

Тэглээ гээд та хүмүүст өөрийн түүхээ ярихаа болих уу?

Таны эргэн ирэх шилжилтийн үеийн нэг чухал хэсэг нь өөрийн амьдралын туршлагаа бусадтай хуваалцах явдал юм. Гэхдээ та үргэлж хүмүүсийн анхаарлын төвд байна гэсэн үг биш шүү. Таныг хол байхад хүмүүсийн амьдралд олон өөрчлөлт гарсан тул тэд ч бас таныг өөрсдийнхөө тухай сонсоосой гэж хүснэ.

Элч Паул бидэнд зөвхөн өөрсдийгөө битгий бодоорой гэдгийг сануулсан. Хүмүүсийг хайрлана гэдэг нь өөрийгөө гэхээс илүү бусдын төлөө санаа тавина гэсэн үг. Тиймээс та эхлээд санаачлага гарга. Хүмүүсийн амар мэндийг асуу. Чин сэтгэлээсээ тэднийг анхааран сонсоорой.

Бас таныг сонсох сайн сонсогчийн төлөө залбираад Бурханыг хүлээгээрэй.

## **Тунгаан бодох нь:**

Гадаадад байсан хэн нэгэнтэй уулзалт товлоод тэр хүнтэй өөрийн түүхээ хуваалцаарай.

Мөн хэнд таны сонсох чих хэрэгтэй байгааг анзаараарай.

## **16-р өдөр: Тусгаарлах ----- Дасан зохицох # 2**

*Израилийн Ариун ЭЗЭН БУРХАН айлдахдаа: “Гэмшил ба амар тайван дунд та нар аврагдах болно. Үнэнч итгэл ба чимээгүй байх нь та нарын хүч мөн” гэлээ. (Исаиа 30:15, Ариун Библи 2013)*

Өөр газар амьдрах нь стресстэй гэдгийг та мэднэ. Та шинэ байдалд дасахын төлөө хичээл зүтгэл гаргаж, энэ нь таньд эрч хүч өгч байгаа боловч нөгөө талаас та бас ядарч туйлдаж байж болох.

Тусгаарлах нь соёлын ядаргаанаас гарч завсарлах тохиромжтой арга юм. Энэ нь та бусдаас өөрийгөө бүрэн тусгаарлах, эсвэл сэтгэлийн тааламжгүй байдлаас өөрийгөө тусгаарлана гэсэн үг. Эсвэл хийж байгаа бүхнээсээ та өөрийгөө салгаж болно.

Та гэртээ буцаж ирээд сэтгэлийн хөдөлгөөнд автаж болзошгүй. Тиймээс дахин засч залруулахын тулд таньд өөрийн гэсэн орон зай хэрэгтэй.

Бурхан ийм тусгаарлалтыг таны бие махбодь, нийгэм, соёлын баттарейг дахин цэнэглэхийн тулд ашигладаг. Бас энэ тусгаарлалтын үеийг таныг сүнслэг тэжээлээр хангахын тулд ашигладаг.

Соёлын өөр нөхцөлд амьдарч байх үедээ хүчээ сэлбэхийн тулд үе үе өөрийгөө тусгаарлаж, сэтгэлээ амрааж, сүнсээ хооллож байгаарай. Чимээгүй орчинд та тогтуун сууж, Бурханд ярих боломж өгөөрэй.

### **Тунгаан бодох нь:**

Та ирснээсээ хойш хэзээ өөрийгөө хүмүүсээс болон амьдралын хурдаас тусгаарласан бэ? Тусгаарлах үедээ хэр зэрэг тэжээл авсан бэ?

Та цагийн хувиараа эргэж хар. Хэзээ нь та өөрийгөө татаж бие сэтгэлийн амралт авч болохоор байна вэ? Ийм цаг гаргаж, түүнийгээ мөрдөөрэй.

## 17-р өдөр: Найдлага

*Юунд ч санаа бүү зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухааныг давах Бурханы амар тайван нь та нарын сэтгэл санааг Христ Есүс дотор хамгаална. (Филиппой 4:6-7, Ариун Библи 2013)*

Байдал санаснаас ч илүү байх үед та аз жаргалтай байдаг. Харин санаж байсан зүйлс бодит байдалтай нийцэхгүй үед таны урам хугарч сэтгэлээр унана. Гэвч санасан зүйлс бүтэхэд сэтгэл амардаг. Таны ирэх үеийн найдвар юу байсан бэ? Та ирэхдээ, эх орныхоо амьдралын талаар, болон таны амьдралд гарах өөрчлөлтүүдийн талаар бодитой ойлголттой ирсэн үү?

Байхгүй юмуу, бодит амьдралаас тасархай найдалтаар амьдрах нь таны байдлыг улам л хэцүүдүүлнэ. Хүмүүс таны хүсч байснаар хандахгүй. Амьдрал таны төсөөлж байсан шиг амар биш. Өчүүхэн жижиг зүйлс хүртэл таны бодсоноос илүү төвөгтэй санагдана. Хамт олон таныг төсөөлж байсан шиг хүлээж аваагүй, ажил олж амжаагүй байгаа гэх мэт.

Та сэтгэл зовнил, гонсойлтынхоо учир шалтгааныг мэдвэл зохих зохицуулалтууд хийж чадна. Таны шинэ амьдрал ямаршуу байх талаар сайн ойлгоцтой ирвэл та хэт их зүйл хүсэхгүй. Байгаа байдалдаа талархалтай бай.

Паул Филиппойчуудад санаагаа зовоохын оронд санал хүсэлтээ Бурханд талархалтайгаар мэдүүлэхийг урамшуулсан.

Байдал таны хүссэнээр болохгүй үед үглэж гомдоллоход амархан. Ийм хандлага нь сөрөг уур амьсгал, үгүйсгэлийг өдөөж, таныг нураах болно. Харин та талархалтай байх шийдвэр гаргах үед, нөхцөл байдлыг өөрөөр харна. Дургуйцэл ба зэвүүцэл нь ямар ч ач холбогдолгүй, харин ч таныг шалихгүй байдалд оруулж жижигрүүлнэ.

### **Тунгаан бодох нь:**

Та ямар найдлагатайгаар гэртээ ирсэн бэ?

Юу таныг гонсойлгож байна вэ?

Филиппой 4:6-7-р ишлэлийг өөртөө хэрхэн хэрэгжүүлэх вэ?

## **18-р өдөр: Ганцаардал**

*Би зүдэрсэн, гачигдсан ч Эзэн намайг санана. Та миний тусламж, Та миний аврагч билээ. Бурхан минь ээ, бүү саатаач! (Дуулал 40:17, Ариун Библи 2013)*

Эргэж ирэх үед сэтгэлээр унах нь хэвийн үзэгдэл. Энэ нь гадаадын амьдрал, найз нөхдөө санаснаас үүссэн уйтгарлал юм. Өнгөрсөн явдал, болон харилцаа холбоогоо хүсэмжлэн санах нь эргэн ирэх үеийн шилжилтийн шат мөн. Бас гуниглалын шалтгаан нь таны ойр хавьд таны байдлыг ойлгох хэн нэгэн байхгүйтэй холбоотой байж болох юм.

Та энэ шилжилтийн шатанд, таны эзгүйд гэр орны амьдрал их өөрчлөгдсөнийг анзаарна. Таны найз нөхдийн амьдрал өөрчлөгдөж, таны ах дүү нар өсөж том болжээ. Магадгүй, таны гэр бүл болон найз нөхдийн амьдралд тохиолдсон онцгой үйл явдлуудад та байгаагүй байх. Гэвч өөрчлөлт зөвхөн нэг талд болоогүй, таны амьдрал ч бас өөрчлөгдсөн. Та ч өөрөө олон талаар өөрчлөгдсөн. Тийм ч учраас та ганцаардаж байгаа.

Дуулал номыг бичигч Бурханы өмнө ирж өөрийн нөхцөл байдлаа нуулгүй шударгаар хэлжээ. Тэр ядуу байгаагаа, дутагдаж гачигдаж байгаагаа мэдүүлсэн. Ингэхдээ Бурхан түүнд санаа тавьж, түүнийг аварна гэсэн үнэн итгэлээсээ бат зууран байсан.

Энэ хэцүү үедээ, Бурхан руу тусламж гуйн залбираарай. Есүс таны байдлыг ойлгодог. Тэр Туслагч ба Зөвлөгч болох Өөрийн Ариун Сүнсээ таньд өгсөн. Тэр бол таньтай хамгийн ойр байгч Нэгэн. (Иохан14)

Та Есүсийг ганцаараа дагалдана гэсэн үг биш гэдгийг сана. Есүс таныг бусад итгэгч нартай хамт Өөрийгөө дагалд гэсэн. Та хуучин сүм чуулгандаа эргэн очих юмуу, эсвэл шинэ Чуулганд хамрагдаарай.

### **Тунгаан бодох нь:**

Та ганцаардаж байвал эргэн тойрноо хар, танаас илүү ганцаардаж байгаа хэн нэгэн рүү очоорой.

## **19-р өдөр: Өөрчлөлт**

*Би хүүхэд байхдаа хүүхэд шиг ярьж, хүүхэд шиг боддог, сэтгэдэг байлаа. Би эрийн цээнд хүрээд хүүхэд зангаа орхисон юм.*

*(1 Коринт 13:1, Ариун Библи 2013)*

Нутагтаа эргэн ирэгсдийн олонхи нь өөрсдийгөө ямар их өөрчлөгдсөнөө мэддэггүй. Нэгэн гадаадын оюутан залуу өөрийгөө өөрчлөгдсөн гэж огт бодоогүй. Харин нутагтаа очоод хэр их өөрчлөгдсөнөө мэдсэн гэж хэлсэн юм.

Зарим өөрчлөлтүүд нь бусдаасаа илэрхий тод байдаг. Жишээ нь, та гадаад хэлээр чөлөөтэй ярьдаг болсон. Мөн урьд нь таны амьдралд байгаагүй хүмүүстэй ойр дотно болсон. Дэлхийн мэдээг сонсдог болсон. Мөнгөө хянамгай зарцуулдаг болсон. Магадгүй та тайван амьдралыг илүүд үздэг болсон гэх мэт.

Хэрэв та эх орноосоо хол байхдаа Есүсийн дагалдагч болсон бол, та шинэ Эзэнтэйгээ хамт ирсэн. Одоо Түүний Үгс болон хүсэл нь таньд хамгийн чухал. Та энэхүү шинэ үнэнч итгэлээсээ болоод нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа мэт сэтгэгдэл төрж магадгүй. Нутагтаа буцсан нэгэн хүн энэ байдлаа илэрхийлж: “Би өөрийн эх орондоо харийн хүн шиг л байна” гэж хэлсэн юм.

Хайрын тухай алдарт 1 Коринт13-р ишлэлд элч Паул устаж үгүй болох сүнслэг бэлгүүдээс хайрыг ялган хэлсэн. Тэр, түр зуурын бөгөөд төгс бус энэ ертөнцөд бид балчир хүүхдээс төлөвшсөн хүн рүү, толинд бүдэг бадаг хардагаас нүүр нүүрээрээ харах хүртэл хэрхэн өөрчлөгддөг болохыг дүрслэн хэлсэн.

### **Тунгаан бодох зүйлс:**

Гэрээсээ хол байхдаа та аль талаараа төлөвшсөн бэ? Ямар хүүхэд зангаа та орхисон бэ?

Есүсийн дагалдагчийн хувьд таньд ямар өөрчлөлтүүд гарсан бэ?



## **20-р өдөр: Тэмцлийн үе шат: Энд байхаас дургүй минь хүрч байна!**

*Гэсэн ч би үргэлж Тантай хамт байна. Та баруун гараас минь барьсан. Та намайг зөвлөгөөгөөрөө удирдаж, Хожим намайг сүр жавхланд угтан авна. (Дуулал 73:23-24, Ариун Библи 2013)*

Эргэн ирэгсэд бүгд энэхүү тэмцлийн үе шатыг дамждаггүй ч магадгүй та ийм байдалд байж болох юм. Та одоо гэртээ байхаас үнэхээр дургүй хүрч, бүх зүйл таны найдаж байснаас тэс өөр байна уу? Та гадаадад байгаа найз нараа санаж, тэднээр дутагдан уйтгарлана. Таньд өөр найз нөхөдтэй болох ямар ч хүсэл алга. Нэг үгээр хэлэхэд та сэтгэлээр унажээ.

Энэ үе шат нь эргэн ирэх шилжилтийн үеийн хамгийн хэцүү нь болохыг туулаад гарсан хүмүүс сайн мэднэ. Ихэнх хүмүүс гадаад руу явахдаа бэлтгэл сайн хийдэг атлаа, нутагтаа ямар ч бэлтгэлгүй ирдэг.

Шилжилтийн энэ үед та соёлын шоконд орж, уур хүрэх, сэтгэл гонсойх зүйл байх ч та иймэрхүү байдалтай удаан байх хэрэггүй. Энэ бол хэвийн, гэхдээ түр зуурын үе шат юм.

Дуулал 73-ийг бичигч нь зовлон шаналал дотроо, Бурхангүй хүмүүстэй өөрийн амьдралыг харьцуулан өгүүлсэн. Бурханыг үгүйсгэдэг хүмүүсийн дэргэд түүний амьдрал зовлонтой байгаа нь шударга бус мэт. Тэр Бурханд сэтгэлээ уудлан: “Зүрх минь гашуудан, дотроо би цоо хатгагдахдаа Би тэнэг, ухвар мөчид байж, Таны өмнө би адгуус адил байжээ” гэж хэлсэн. Тэр Бурхан түүнийг орхиогүй, түүнтэй хамт байгааг мэдэж байсан юм.

### **Тунгаан бодох нь:**

Дуулал 73:21-26 ишлэлүүдийг тунгаан, бодож уншаарай.

## **21-р өдөр: Уй гуниг**

*Вавилоны гол мөрнүүдийн дэргэд, тэнд бид суугаад Сионыг санахдаа уйлав. Уд модонд, тэдэн дунд ятга хөгжмүүдээ бид өлгөө. Учир нь олзлогчид маань тэнд биднээс дуун найргийг зовоогчид маань зугаа цэнгэлийг нэхэн “Сионы дуунаас бидэнд дуулж өг” хэмээв. Бид ЭЗЭНий дууг харь нутагт хэрхэн дуулах вэ? (Дуулал 137:1-4, Ариун Библи 2013)*

Та гэртээ эргэн ирээд аз жаргалтай байх ёстой бус уу? Гэтэл та уйтгартай байдаг. Хамгийн сайхан энэ үедээ та юунд уйлах нь холгүй байдаг билээ? Та юунд амархан ундууцаж уцаарлана вэ? Сэтгэлийн энэ бүх хөдөлгөөнүүд хаанаас ирэв?

Та ирсэн орон, соёл, хүмүүс, тэндэх амьдралаа үгүйлж байгаа бизээ. Гадаадад сураад буцсан нэгэн эмэгтэй эхний нэг жилийн турш сэтгэл гутралд ороод яахаа мэдэхгүй болсноо ярьсан юм.

Сэтгэл санаа ямар байгаа, юу болж байгаадаа нэр өгөх нь шилжилтийн энэ үед хэрэгтэй байдаг. Уйлах, уйдаг нь уй гунигийн нэг хэсэг мөн. Ингэж нэр өгөх нь хэнийг болон юуг санаад байгаагаа ярихад тус болно.

Израилчууд харийн нутагт Иерасулимийг санаж байсан. Тэд төрсөн нутгаа санаад мэгшин уйлж байсан. Магадгүй та ирсэн газраа тэдэн шиг санан үгүйлж байж болох юм.

### **Тунгаан бодох нь:**

Та зураг, видео, бэлэг дурсгалын зүйлсээ үз. Тэнд байхад тохойлдсон чухал үйл явдлууд болон хүмүүсийг санан дурсах нь таньд тайтгарал авчрах болно.

Мөн гадаадад байсан тухайгаа хэн нэгэнд яриарай.

## **22-р өдөр: Өрөвдөн хайрлах сэтгэл**

*Есүс нийт хот тосгодоор явж, синагогуудад зааж, хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, бүх төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа. Хүмүүсийг хараад Тэр өрөвджээ. Учир нь тэд хоньчингүй хонь мэт хаягдан туйлдсан байлаа.*

*(Матай 9:35-36, Ариун Библи 2013)*

Биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн үйлчлэлээр Азид хэдэн сар ажилласан коллежийн шинэхэн төгссөн оюутан эмэгтэй нүдэнд нь нулимс цийлэгнэн байж: “Би тэдний амьдралын тухай сонсоод зүрх сэтгэл минь маш их өвдөж шаналсан. Би одоо юу хийх ёстой вэ?” гэж надаас асуув.

Би түүнд: “Бурхан чиний зүрх сэтгэлийг шинэчлэхийг хүсч байна. Чи одоо өрөвдөн хайрлах сэтгэлтэйгээр үүнд бэлэн болжээ. Одооноос эхлэн Бурхан чамайг яаж өөрөөр амьдрахыг хүсч байна гэдгийг сонсоорой” гэж хэлсэн юм.

Гадаадад байхад таны сэтгэлийг юу их өвтгөж байсан бэ? Эсвэл, эх орондоо ирээд харсан зүйлдээ таны зүрх сэтгэл өвдөн шаналж байна уу? Та эх орноосоо хол амьдарч байхдаа ядуурал, зовлонгоос хамгаалагдсан байсан бол одоо та энэ бүхнийг өдөр тутам өөрийн нүдээр харж, амсаж байгаа.

Матай 9:37-38-д, Есүс хүмүүсийн аж амьдралыг хараад өрөвдөн сэтгэл нь хөдөлсөн. Тэд маш их гачигдан дутагдаж байсан тул Тэрээр дагалдагч нартаа: “Ургац арвин ч ажилчид цөөн байна. Тиймээс ургацдаа ажилчид явуулахыг ургацын Эзэнээс гуйцгаа” гэж заавар өгсөн. (Ариун Библи 2013).

Та нутгаасаа хол амьдарч байх үедээ хоньчингүй хонин сүрэг мэт “тарж”, “туйлдсан” ямар хүмүүстэй таарч байсан бэ? Одоо таны эх оронд туйлдсан ямар хүмүүс байна вэ?

### **Тунгаан бодох нь:**

Таны хамт олон дотор гачигдан дутагдаж байгаа хүмүүст туслах ямар арга замууд байгааг бодоорой. Орон нутгийн Чуулган юмуу ямар нэг байгууллагад сайн дурын ажил хийх.

Таныг гадаадад байхад Бурхан таны залбиралын амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ?

Та нутагтаа ирснээс хойш Бурханаас юу гуйж хүсч байгаа вэ?

## **23-р өдөр: Алдаа гаргах нь**

*Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ.*

*(1Иохан 1:9, Ариун Библи 2013)*

Алддаггүй хүн гэж байхгүй. Мэдээж, та ч мөн алдаа гаргасан бизээ. Шинэхэн ирсэн хүний хувьд таны алдаа нь соёл болон харилцаан дээр илэрнэ. Жишээ нь: Танай нутгийнхан тойруу замаар ярьдагыг нь та мартсанаас, таны шулуухан яриа хэн нэгнийг гомдоож мэднэ. Цагийн зөрүүнөөс болоод уулзах цагаасаа хоцрон бусдын дургүйг хүргэж магад. Эдгээр алдаанууд болон соёлын зөрчилдөөн бол эх орондоо дасан зохицох процессын нэг хэсэг юм.

Би нэгэн үйл ажиллагаанд энгийн хувцастай очоод эгчийгээ эвгүй байдалд оруулж билээ. Манайхан яаж хувцасладагийг би мартсан байсан юм. Бас нэг хүн Америкаас буцаж ирээд тэнд байдаг шигээ хоол хүнсээ нөөцөлсөн нь байгаа айлынхаа хүнийг гомдооход хүргэжээ. Ингэж тэр хүн тэндхийн хүмүүс (Америкууд шиг хүнсээ бөөнөөр нь авч нөөцөлдөггүйг мэдсэн юм.

Алдаа гэдэг бол бардам зан юмуу, хувиа хичээсэн байдлаас үүдээгүй басанамсаргүй үйлдэл юм. Иймэрхүү алдаануудыг тохирох уучлалт гуйснаар амархан засч болно. Гэхдээ, хэрэв та өөрийнхөөрөө зүтгэх юмуу, залруулгыг хүлээж авахгүй байх юм бол таны гэнэн алдаанууд гэм нүгэл рүү хөтөлж мэдэхийг анхаар. Ийм үедээ та Бурханаас болон тухайн гомдоосон хүмүүсээс уучлал гуйгаарай.

Нэг гаргасан алдаагаа дахин бүү гарга. Гадаадад өөр соёлд суралцаж байсан шигээ тэднээс суралц. Хэзээ нэг цагт тэд ч бас танаас сурах болно.

### **Тунгаан бодох нь:**

Та ямар алдаа гаргаж хөглөсөн бэ?

Та ирээдүйд эх орондоо буцан ирэгсдэд ямар туршлагаа хуваалцах вэ?

## **24-р өдөр: Шүүмтлэмтгий авир**

*Хайрт ах дүү нар минь, үүнийг мэдэгтүн. Хүн бүр сонсохдоо түргэн, ярихдаа удаан, уур хилэнд хойрго байг. Учир нь хүний уур хилэн Бурханы зөвт байдлыг биелүүлдэггүй юм.*

*(Иаков 1:19-20, Ариун Библи 2013)*

Та гадаадад амьдрах үедээ шинэ соёлын үнэ цэнэ, юмыг шинэлэг байдлаар хийхийн сайхныг олж авсан. Тиймээс та гадаадын амьдралаа санагалзаж, эх орондоо хүмүүс яаж амьдарч байгаад шүүмжлэлтэй хандаж байгаа байх.

Хүмүүс ямар зохион байгуулалтгүй юм бэ? Тэд ямар хэрэгт дуртай, сониуч юм бэ? Тэд ямар их материаллаг сонирхолтой юм бэ? Яагаад ийм их зан үйл байдаг юм бэ? Хүмүүс үргэлж ирж, ярихаа зогсох болоогүй юм байхдаа? Хүмүүс яагаад спортонд ингэтлээ их дурлана вэ? Хэрэггүй зүйлд ямар их мөнгө үрдэг юм бэ? Тэгснээс ядуу хүмүүст туслаж болдоггүй юм байхдаа? гэх мэт асуултууд таньд байж болох юм.

Та өөрийн соёлоос өөр соёлд амьдрах туршлагатай болж, юм үзэж нүд тайлжээ. Одоо та өөрийн орны соёлыг өөр орны соёлын томруулагч шилээр харж байгаа нь тэр. Нэгэнд нь болж байгаа амьдралын хэв маяг нь нөгөөд нь заавал таарах албагүй юм.

Иаков ном бол таньд маш сайн сануулга болно. Хэрэв та уурлах, шүүмжлэхээ түрүү барилгүй хүмүүсийг тайван сонсож чадвал нөхцөл байдлыг илүү сайн ойлгоно. Үүнтэй адил, та өөрийн соёлыг аажмаар дахин сурч, уужуу тайван хандвал хүмүүс яагаад ийм байдгийг илүү сайн мэдэх болно.

Таньд өөрийн соёлоо дахин сурах ямар арга замууд байна вэ? Хэн таны Монгол соёлын зөвлөгч байж болох вэ?

## **Тунгаан бодох нь:**

Та энэ өдрийг өөрийн эх орон болон хүмүүсийн эерэг сайн зүйлсийг олж харахад зориулаарай.

## **25-р өдөр: Шийдвэр гаргах нь**

*Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчдадаа захирагд. Та бүгд бие биендээ даруу хандах байдлаар хувцасла. Учир нь Бурхан бардмыг эсэргүүцдэг, харин дарууд нигүүлсэл өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая. (1 Петр 5:5-7, Ариун Библи 2013)*

Та одоо ямар шийдвэртэй тулгарч байна вэ?

Гэртээ ирсэнээс хойш шийдвэр гаргахад ямар хэцүү, стресс ихтэй байгаад та гайхаж байгаа байх. Учир нь та илүү олон хүмүүс, хүчин зүйлс, сонголтуудыг бодож үзэх хэрэгтэй болно. Дээр нь та өөрөө өөрчлөгдсөн, таны амьдралд хандах хандлага ч мөн өөр болсон байгаа.

Та одоо ямар нэгэн зүйлийг зөв буруу аль нь болохыг дэнсэлж сууна уу? Энэ нь таны хувийн сонирхол уу? Эсвэл та энэ шийдвэрийг гаргаснаар хэн нэгнийг баярлуулахыг хүсч байна уу? Энэ талаар Библид юу гэж хэлсэн байна вэ? Шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл таньд байна уу? Та ямар ч шийдвэр гаргасан, энэ нь таны Бурханд итгэх итгэлийг эрчилж өгөх болно.

Тиймээс, Элч Петрийн зөвлөлгөө нь өнөөгийн бидэнд ч хамаатай. Петр эв нэгдэл муутай Чуулганы ахлагчид болон залуучуудад бичсэн захидалдаа, тэднийг Бурхан болон бие биентэйгээ хамаатай учир тэднийг зохистой цагт өргөмжлөлд хүргэх дөлгөөн даруу зан чанарыг өмсөхийг ятган уриалсан. Хэрэв тэд даруу байвал Бурхан тэдний талд байна.

Тэр таньд ч мөн санаа тавьдаг учир хэцүү шийдвэр гаргахдаа зүрхээ даруусган Бурхан руу хандан, Түүнд санаа зоволтоо өгөөрэй. Бурханд таны төлөөх хамгийн сайн шийдвэр үргэлж байдаг тул, Түүний заавар, мэргэн ухаанд итгээрэй.

## **Тунгаан бодох нь:**

Сургаалт Үгс 3:5-6-ийг тунгаан унших.

Таныг шийдвэр гаргахад ямар тус дэм таньд хэрэгтэй байна вэ?

## **26-р өдөр: Дассан үе: Энэ бол миний эх орон.**

*Ирээд, Бурханы үйлсийг үз. Хүний хөвгүүдэд үйлдсэн нь сүрдэм!  
Тэрээр далайг хуурай газар болгосон. Тэд хөлөөрөө алхаж голыг  
гаталсан. Тэнд бид Түүнд баярлацгаав.  
(Дуулал 66:5-6, Ариун Библи 2013)*

Одоо та шилжилтийн шатны сүүлийн хэсэгт ирлээ. Энэ үед сэтгэл сайхан болно. Үүлс арилж, та одоо дажгүй сайн байгаа. Та гэртээ ирснээс хойш нилээд хугацаа өнгөрч, дасан зохицох хугацаа ч хангалттай байлаа.

Энэ шатанд, та нэг талаас эх орныхоо иргэн байх, нөгөө талаас гадаад хүн байх хоёрын аль алиных нь тэнцвэрийг олох чадвартай болно. Та олон өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрч, даван туулсны зэрэгцээ өөрийн гэсэн шинэ дуу хоолой болон шинэ байр сууриа олсон. Мөн та өөрийн шинэ дүр төрхийг олж, өөртөө итгэх итгэлтэй болсон. Иймээс та эх орондоо байгаадаа болон бусдад ерөөлийн суваг болж байгаадаа сэтгэл хангалуун байгаа.

Байдал дээрдэнэ.

Та Дуулал номыг бичигч шиг: “Ирээд Бурханы үйлсийг үз” гэж хэлмээр дахин баяр хөөртэй болно. Учир нь та “Буцаад нисмээр үе” болон “Тэмцлийн үе шатнаас” нэгэнт гарсан! Таны шилжилтийн үе дэхь Бурханы мутарыг олж хараад Түүнд талархал магтаалыг өргөөрэй.

Анхааруулга: Та эргэн ирэх үедээ тодорхой хугацааны туршид өөр өөр үе шатуудыг дамжих болно. Бас та амьдралынхаа аль нэг талбар дээр “Дасах үе шатандаа” байхад өөр талбарууд дээрээ “Тэмцлийн үедээ” ч байж болзошгүй.

## **Тунгаан бодох нь:**

Таньд одоо ямар хүсэл мөрөөдөл байна вэ?

Эргэн тойрноо хараад, Бурханаас дараахь зүйлсийг таньд харуулж өгөхийг гуйн залбираарай:

- Түүний ямар бүтээлд аж ахуйн эрхлэгч буюу няравын хэрэгцээ байна вэ?
- Таны амьдарч байгаа газар ямар барилга байгууламж, бүтээн байгуулалт хэрэгтэй байна вэ?

## **27-р өдөр: Холбогдох---Дасан зохицох # 3**

*Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн. (Иохан 1:14, Ариун Библи 2013).*

*Үүр шөнөөр Тэр босоод гадагш гарч зэлүүд газар очин, тэндээ залбирч байв.*

*(Марк 1:35, Ариун Библи 2013)*

*Тэдний гэрт Есүсийг тухлан суухуйд татвар хураагчид ба нүгэлтнүүд олноороо Есүс ба шавь нарынх нь хамт тухлан суув. (Марк 2:15, Ариун Библи 2013)*

Холбогдох гэдэг нь та эх орныхоо амьдралд шингэн орно гэсэн үг. Буцаж ирэгсдийн нөлөөгөөр улс орны түүх дахин бичигдсээр ирсэн билээ. Та бол Бурханы алдрын төлөө болон бусдад сайнаар нөлөөлөхөөр Бурханы сонгосон хүмүүсийн нэг шүү. Та өөрийн ертөнцийг өөрчлөхийг хүсч байгаа. Та нэгээс илүү гадаад хэл ба соёлыг эзэмшсэн дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай хүн. Тиймээс таньд амьдралыг өөрчлөх санаанууд байгаа.

Гэхдээ, нэгдэн нийлэх явцдаа ухаалаг, болгоомжтой байгаарай.

Эх орондоо байхдаа эрүүл ухаантай, сэтгэлийн тэнцвэртэй бай. Шаардлагатай үед тусгаарлалт зайлшгүй чухал. Алдаагаа засах, зохицохын тулд бусдыг үлгэрлэн дууриах хэрэгтэй. Эх орондоо үр бүтээлтэй байхын тулд эвлэн нэгд. Эдгээр гурван аргыг гурвууланг нь хэрэглээрэй.

Есүс өөр соёлд хэрхэн амьдрахыг сайн мэддэг байсан: Хэдийгээр Түүний амьдралын үнэ цэнэ, утга учир нь энэ дэлхийнх биш байсан боловч энэ дэлхий рүү бидний дүр төрхөөр ирсэн. (Хуулбарлах - Иохан 1:14); Тэр тусгаарлан холддог байсан. (Холдох- Марк 1:35); мөн хүмүүсийн амьдралд бүрэн орж, жаргал зовлонг нь хуваалцдаг байсан. (Холбогдох- Марк 2:15)

### **Тунгаан бодох нь:**

Хуулах, холдох, холбогдох. Та одоо энэ аргуудыг хэрхэн тэнцүүлж байна вэ?



## **28-р өдөр: Итгэлээ сэргээх**

*Тэгэхээр одоо ЭЗЭНээс эмээн, гэм зэмгүй үнэн шударгаар Түүнд үйлчлэгтүн. Евфрат мөрний цаана болон Египетэд өвөг дээдсийнхээ мөргөж байсан мөнөөх бурхдыг авч хаяад ЭЗЭНд үйлчил. ЭЗЭНд үйлчлэх нь та нарын хувьд тааламжгүй байваас хэнд нь үйлчлэх вэ гэдгээ өнөөдөр өөрөө сонгог. Евфрат мөрний цаана эцэг дээдсийнхээ үйлчилж байсан бурхдад мөргөх үү эсвэл нутаглаж буй газрынхаа аморичуудын бурхдад үйлчлэх үү? Харин би болон манай гэрийнхэн бид ЭЗЭНд үйлчилнэ гэлээ. (Иошуа 24:14-15, Ариун Библи 2013)*

Тодорхой өөрчлөлт гарах дөхөж байлаа. Иошуа өтөлж, насан эцэслэх дөхөж байх үед Бурхан түүнд Израйлийн овгүүдийн удирдагчдад хэлэх үгийг өгөв. Иошуа 24-р бүлгийн эхний хагаст Израйлчуудын нэг нутгаас нөгөөд нүүдэллэн амьдарч байсан түүхэн үе дэхь Бурханы оролцоог тэдэнд эргэн сануулдаг. Тус бүлгийн 2-р хагаст Иошуа тэднийг шийдвэрээ гаргах сонголт өгөхөөр дуудсан тухай өгүүлдэг.

Израйлчууд хэнд үйлчлэх бол? Тэднийг өмөөрөн хамгаалж байсан Амьд Бурхан Эзэнд үү? эсвэл, урьд өмнө юмуу одоо амьдарч байгаа нутгийнхаа бурхад шүтээнүүдийг үү?

Та хэнд үйлчлэх вэ? Гэрээсээ хол амьдарч байхдаа та магадгүй тэр орны шүтээнүүдэд (материаллаг сонирхол, гадаад үзэмж г.м) татагдаж байсан бол одоо эх орондоо байгаа шүтээнүүдийн өгөөшинд орж болзошгүй. (мөнгө, амжилт, хүлээлт & горьдлого)

Яг одоо та Есүс Христэд итгэх итгэлээ сэргээх хамгийн тохиромжтой цаг үедээ байна. Зөвхөн Есүс таны бишрэл хүндлэлийг авах зохистой Нэгэн. Таны чин сэтгэлийн үйлчлэл, үнэнч итгэл зөвхөн Түүнд зориулагдах учиртай.

### **Тунгаан бодох нь:**

Та ямар шүтээнүүдийг хаях хэрэгтэй байна вэ?

Та итгэлээ сэргээхийн төлөө өөрийнхөө залбирлыг бичээд найзтайгаа хуваалцаарай.

## **29-р өдөр: “Та өөр хэн нэгнийг явуулаач”**

*ЭЗЭН түүнд: Хүмүүний амыг хэн бүтээсэн бэ? Хүмүүнийг хэн хэлгүй эсвэл дүлий, хараатай эсвэл сохор болгодог вэ? ЭЗЭН Би биш гэж үү? Тиймээс одоо яв! Би амтай чинь хамт байж, юу хэлэхийг чинь чамд заана гэв. Харин тэр: “Өө Эзэн, Та өөр хэн нэгнийг явуулаач!” гэв. (Гэтлэл 4:11-13, Ариун Библи 2013)*

Бурхан таныг эх орондоо байх энэ үед таныг болон таны гадаадад эзэмшсэн мэдлэг туршлагыг хэрхэн ашиглахыг хүсч байна вэ?

Итгэлийн хэн нэгэн баатрын тухай бод.

Гэтлэл 1-4 унших.

Мосе Египэтээс алс хол олон жил амьдарсан. Хүний нутагт тэрээр гэрлэж, үр хүүхэдтэй болсон. Жирийн нэг өдөр Бурхан түүний амьдралыг гайхалтай илчлэлээр өөрчилсөн юм. Тэр Бурхан бол Мосегийн өвөг дээдэс Абрахам, Исаак, Иакоб нарын дээдлэн хүндэлж байсан тэр Бурхан мөн байлаа. (Гэтлэл 3:6) Тэгээд Бурхан Өөрийн төлөвлөгөөг эхэлж Мосед Фараоны өмнө очин түүний ард түмнийг удирдан Египетээс гарга гэж хэлсэн.

Хонь хариулж байсан хүн, харин одоо Фараоныг эсэргүүцэн бүхэл бүтэн ард түмнийг удирдах дуудлага авсан юм! Мосе айн балмагдаж өөрийгөө энэ дуудлаганд тохирох хүн биш гэж бодсон нь ойлгомжтой. Тэр янз бүрийн шалтаг тоочсон боловч, тэр бүхэнд нь өгөх хариулт Бурханд байсан. Мосе Бурханаас өөр хүнийг явуулахыг шалан гуйхад (Гэтлэл 4:13)

Бурхан Мосед туслуулахаар Аароныг явуулдаг. Ингээд ах дүү хоёр ард түмнээ удирдсан юм.

### **Тунгаан бодох нь:**

Таныг эх орондоо ирсэн энэ үед Бурхан таныг юу хий гэж дуудаж байна вэ? Ямар шалтаг таныг энэ дуудлагаас холдуулж байна вэ? Танд туслах Аарон шиг хүн хэн байна вэ?

### **30-р өдөр: Энэ цагийн төлөө**

*Хэрэв чи энэ үед чимээгүй байвал иудейчүүдэд өөр газраас тусламж, аврал ирж, харин чи болон чиний эцгийн гэр сөнөнө. Хааны эрх дархад хүрсэн чинь энэ цагийн төлөө ч юм бил үү, хэн мэдэх вэ? (Естер 4:14, Ариун Библи)*

Естерийн түүх бол харь нутагт цөлөгдсөн, еврей, өнчин, бага үндэстэн, гадаадын залуу бүсгүйн амьдралд урьдчилан төсөөлөөгүй боломж нээгдсэн тухай түүх билээ. Тэр авга ах Мордехайг сүүдэр мэт дагагч бяцхан охиноос, өөрийн ард түмнийг хувь тавилан руу нь хөтлөх цорын ганц хүн болсон юм. Гэвч энэ нь нэг өдөрт болоогүй.

Орон даяар удаан эрэл хайгуул хийсний эцэст Вашти хатны байр суурийг Естерт өгдөг. Естер хатан болохоосоо өмнө авга ахдаа үнэнч дуулгавартайгаар олон жил амьдарсан. Түүхийг дэлгэн харахад, Естер хатан Мордахуан ятгалга, урам зориг өгсөн үгийг хүлээн авч, өөрийн байр сууриа ашиглан ард түмнийхээ төлөө хаанд бараалхахаар шийдвэр гаргадаг. Тэр хэрэгтэй үед зоригтой алхам хийж, өөрчлөлтийг бий болгосон юм.

Магадгүй, Бурхан үүн шиг цагийн төлөө таныг эх оронд тань авчирсан бизээ. Бурханд таны төлөө агуу төлөвлөгөө бий.

### **Тунгаан бодох нь:**

Одоо таны амьдралын ямар цаг үе вэ? Таны мэргэжлийн хувьд, таны хамт олны болон таны эх орны түүхийн хувьд ямар цаг үе вэ? Та өөрийн ард түмний авралын төлөө ямар үүрэг гүйцэтгэж болох вэ?

Естер Мордехайгийн ачаар нөлөө бүхий, хүчирхэг байр суурьтай болж өссөн. Одоо таны амьдралд таныг шахаж, чиглүүлж, үйлчилж, өсөх боломжуудыг нээж өгөх хэн байна вэ?


## Төгсгөлийн Үг

Та магадгүй олон газарт амьдарч байсан байх. Цаашдаа ч дахин өөр газар руу нүүх юмуу эсвэл аялах бизээ. Та хаашаа ч очсон, тэндээ түр оршин суугч байх болно. Учир нь та бол уран барилгач Бурханы мутраар баригдсан суурь бүхий хот дахь байнгын гэртээ амьдрахаар бүтээгдсэн. Тэр бол таны мөнхийн гэр орон: Баяр хөөрөөр дүүрэн Бурханы оршихуй!

Өнгөрсөн долоо хоногууд нь таны өмнөх шинэ амьдралын зөвхөн эхлэл юм. Өдөр тутмын эдгээр уншлагауд нь таны ирэх үеийн шилжилтийн зөвхөн үндсэн сэдвийг хөндсөн байгаа. Тиймээс таньд асуух өөр асуултууд гарч, амьдралын өөр талбарууд дээрээ тусламж авах хэрэгцээ тулгарч болзошгүй. Ийм үед та эх орондоо буцаж ирсэн туршлагатай хэн нэгнээс зөвөлгөө аваарай. Мөн чуулганыхаа пастор юмуу эсвэл өөр төлөвшсөн итгэгчид таньд туслана. Бас “Think Home” шинэчилсэн сурах бичиг дээрхи шинэ сэдвийг унших нь тустай. Үүнийг InterVarsity номын дэлгүүрээс авч болно. ([tiny.cc/t-home](http://tiny.cc/t-home))

## Хавсралт

### ШИЛЖИЛТИЙН ҮЕ ШАТУУД



Зарим хүмүүс шилжилтийн үе бүрт хэд хэдэн өндөр нам түвшинд байж болно. Жишээлбэл, олон болон нэгэн зэрэг олон "U" долгио нь нийгмийн болон сэтгэл хөдлөлийн өөрчлөлт гэхээсээ илүү өөр өөр үе шатанд тохойлдсон академик тохируулгатай холбоотой байж болно.

Энэхүү графиктай номын хавчуургыг Интерварситу дэлгүүрээс авч болно. ([tiny.cc/bkmtk](http://tiny.cc/bkmtk)).

Лиза Есринели Чинн & Дэвид Поллок. 2011 ИнтерВарситу Христитгэгчдийн Нөхөрлөл /АНУ

## **Зохиогчийн тухай**

*Лиза Еспинели Чинн бол АНУ дахь InterVarsity Христийн Нөхөрлөлийн Олон Улсын Оюутны Үйлчлэлийн үндэсний захирал. Тэрээр “Соёл ба зан заншил”: Эргэн ирэх үеийн дууриах тоглоом, “Гэртээ байгаа гэж бод”: Гадаад оюутнуудын гэртээ ирэх үеийн зөвлөмж болон богино хугацаагаар илгээгдсэн илгээлтийн эзэд, удирдагчдад зориулсан зөвлөмж номуудыг зохиогч. Лиза нь Wheaton Graduate School- ийг Харилцааны Мастер зэргээр төгссөн, филиппин эмэгтэй.*

## **Гэртээ ирлээ номын тухай сэтгэгдэлүүд**

“Юуны өмнө таньд энэ гайхалтай эх сурвалжийг гаргасанд БАЯРЛАЛАА. “Гэртээ ирлээ” ном нь янз бүрийн үе шатуудын хугацааг нарийн тодорхой гаргаж өгсөн нь надад маш их тус болсон. Энэ нь гэртээ ирсний дараахь эхний өдрүүдийн уйлаан болон олон олон сэтгэл хөдлөлийн дуу хоолой дундахь хүчтэй хамтрагч минь байлаа.”

- Жесика Фокс, Зүүн өмнөд Азиас буцсан Англи хэлний багш.

“Би эх орондоо хоёр жил болоод АНУ-д буцаж ирэхэд, Гэртээ ирлээ ном нь шилжилтийн үеийн хэвийн дүр зургыг илүү ойлгоход тусалж, сэтгэлийн хөдөлгөөн ба бодлоо хянаж цэгцлэх арга замыг зааж өгч, Бурханд намайг “хэлбэржүүлж өөрчлөх” боломж өгөх хэрэгтэйг надад ойлгуулсан.”

- Аннелиес Ван Броклин, InterVarsity-н ажилтан, Guatemala дахь илгээлтийн эзэн.

“Гэртээ ирлээ” бол Америкт буцан ирж байгаа гадаад оюутнуудад маш сайн хэрэгсэл юм. Мөн богино хугацааны илгээлтээс буцаж ирсэн хүмүүс үйлчлэлээ тайлагнах, удаан хугацаагаар явах талаар бодож үзэхэд үнэхээр хэрэгтэй материал мөн.

- Хелин Луиси-Милс, InterVarsity Global төсөл болон Global Urban Trek-ын Захирал.

“Гэртээ ирлээ” энэхүү шинэ өргөл нь эх орондоо буцаж байгаа Христитгэгч гадаадын оюутан бүрт зайлшгүй байх ёстой зүйл мөн. Нимгэн, сэтгэл татсан энэ товхимол нь гэртээ ирсний дараахь эхний 30 хоног бүрт зориулсан хуудастай. Библийнхээ завсарт хийж болохоор учир гар чөмөдэнд илүү зай эзлэхгүй. Өдөр бүрт тохирсон Библийн ишлэл, буцаж ирэх үед тохиолддог янз бүрийн асуудлууд болон баяр хөөрийг тусгаад, дараа нь эрэгцүүлж бодох зүйлсийг оруулж өгсөн. Энэ номыг уншихад өдөрт 20-хон минут зарцуулсан хүмүүс тэдэнд юу болоод байгааг ойлгох болно. Мөн тэдний гэр бүл болон найз нөхдөд ч байдлыг ойлгоход туслана. Энэ нь шилжилтийн хэцүү үед тэднийг Бурханы амьд оршихуйд ойртуулж, тэдний төлөө Бурханы сайн төлөвлөгөө байгааг сануулах болно.

- Дебби Диксон, Их Британи дахь Friends International-ийн Төлөөлөл

[INTERVARSITY, ISM \(International Student Ministry\), www.intervarsity.org/ism](http://www.intervarsity.org/ism)

